

МОНГОЛЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ЭДИЙН ЗАСГИЙН ДИПЛОМАТЫН ШИНЭ ПАРАДИГМ

Д.Уламбаяр¹

Т.Уянгаа²

Эдийн засгийн дипломат ажиллагаа гэдэг нь улс хоорондын болон улс, бусад оролцогчдын (олон улсын худалдаа-эдийн засаг, санхүүгийн байгууллага, мөн ч үндэстэн дамнасан корпорациуд) хооронд явагдаж буй улс төр, эдийн засгийн харилцааг зохицуулж буй менежмент хийгээд маркетинг юм гэж Английн судлаач Николас Бейн, Стефен Вүүлькок нар бүтээлдээ бичжээ.³ Менежмент бол уян хатан удирдах ур чадвар, урлаг бөгөөд маркетинг нь түншээ судлах, итгэн үнэмшүүлэх, өөрийн талд татах гэсэн үг ажээ. Өөрөөр хэлбэл хоёр болон олон талт болон глобал эдийн засгийн харилцааг яриа хэлэлцээний замаар уян хатан зохицуулах шинжлэх ухаан, урлаг юм. Мөн бодлогоо ухуулан ойлгуулах, хүлээн зөвшөөрүүлэх арга хэрэгсэл болдгийг дипломатын түүх харуулсан бөгөөд эдүгээ ч харуулсаар байна.

Дипломат ажиллагаанд улс төрийн бодлого тэргүүлэх шинжтэй боловч, эдийн засгийн чиглэл тодорхойлох шинжтэй байх нь түүхэнд олонтой байсан бөгөөд даяаршлын эрин үед хөгжлийн асуудал тэргүүн зэрэгт тавигдаж, түүний ач холбогдол улам бүр өсөн нэмэгдэж байгаа нь бидний нүдний өмнө илт болов.

1 ХИС-ийн Олон улсын харилцаа, нийгэм судлалын сургуулийн захирал

2 Монгол, ЕХ-ны түншлэлийг дэмжих төвийн төслийн шинжээч, олон улсын эдийн засагч

3 Nicolas Bayne, Stephen Woolcock. The New Economic Diplomacy: Decision-Making and Negotiation in International Economic Relations. L.: 2007, p. 45

Эдийн засгийн дипломат ажиллагаанд улс орнуудаас *Bretton Woods Institutions*-тэй тогтоосон хамтын ажиллагаа маш чухал ач холбогдолтой байсаар ирсэн билээ.

Bretton Woods system байгуулагдах шаардлага, үр дүн

Алтан баталгаатай мөнгөн (цаасан) дэвсгэрт гүйлгээнд байсан Сонгодог алтан стандартын үе дэлхийн I дайн эхэлснээр 1914 онд төгсгөл болж, алтан баталгаагүй мөнгөн дэвсгэрт гүйлгээнд их хэмжээгээр зонхилох болж, дэлхийн эдийн засагт гүн хямрал гаргах шинж тэмдэг мэдрэгдэж эхэлсэн байна. Үндэстнүүдийн Холбооны эвээл дор зохиогдсон 1920 оны Хаагын бага хурал, 1922 оны Генуягийн олон улсын эдийн засгийн бага хурал сонгодог алтан стандартад эргэж орох хүчин чармайлтыг гаргасан боловч амжилт олж чадаагүй юм. 1920-иод оны сүүлчээс колони эзэмшигч орнуудын хооронд эдийн засгийн протекционист бодлого газар авч, дэлхийн II дайн улс орнуудын эдийн засаг, олон улсын эдийн засгийн харилцааг бүхэлд нь сүйрүүлсэн юм.

Тийнхүү дэлхийн II дайны сүүлчийн улирал Нормандад II фронт нээгдсэний дараахан 1944 оны 7 дугаар сарын 1-нээс 7 дугаар сарын 22-ны хооронд АНУ-ын санаачилагаар Нью-Хэмшир муж улсын үзэсгэлэнт Вашингтон уулын «*Bretton Woods*»-ын аманд орших «*Washington Hotel*» хэмээх амралт, сувилалын алдартай газарт дэлхийн 44 орны 700 гаруй төлөөлөгчид хуран чуулж, дайны дараах олон улсын валют, санхүү, зээл, худалдаа-эдийн засгийн шинэ дэг тогтолцоог журамлах асуудлыг иж бүрэн хэлэлцэж үндсэнд нь шийдвэрлэсэн юм. Энэхүү түүхт бага хурлын дүнд АНУ-ын Сангийн сайдын орлогч Харри Декстер Уайт, Английн төв банкны захирал, Кэмбрижийн их сургуулийн профессор, лорд Жон Мэйнард Кейнес нарын төслөөр ОУВС, Шинэчлэл, хөгжлийн олон улсын банк буюу Дэлхийн банк, Олон улсын худалдааны байгууллага буюу ГАТТ-ын үндэс суурь тавигдсан нь түүхэн амжилт болсон юм. Үүнийг олон улсын эдийн засгийн харилцаа, дипломатын түүхэнд «*Bretton Woods System or Institutions*» гэж нэрлэдэг. ОУВС-гийн Дүрмийг баталсан хэлэлцээрт 39 орон гарын үсэг зурж, хэлэлцээр 1945 оны 12 дугаар сард хүчин төгөлдөр болсон билээ. ОУВС, Шинэчлэл хөгжлийн олон улсын банк 1947 оны 3 дугаар сарын 1-нээс НҮБ-ын төрөлжсөн статустайгаар үйл

ажиллагаагаа Вашингтон хотноо явуулж эхэлжээ. Дэлхийн II дайны төгсгөлд АНУ дэлхийн алтны нөөцийн бараг 80 хувийг эзэмших болж, 1934 онд Конгрессоор батлагдсан Алтны тухай хуульд 1 унц алтыг 35 ам. доллар байхаар заасныг ОУВС-гийн дүрэмд зүйлчлэн оруулснаар дэлхийн II дайны дараа ам. доллар олон улсын төлбөр, тооцооны гол, үндсэн валют болсон байна. Энэ нь АНУ-ын эдийн засгийн дипломат ажиллагааны шууд үр дүн, түүхэн ялалт болсон юм. Өнөөгийн глобал валют, санхүү, зээлийн шинэ дэг тогтолцооны үндэс суурь нь *Bretton Woods*-ын бага хурлаар ийнхүү тавигдсан ажгуу.

Өрнөдийн эдийн засгийн хөгжилд ОУВС-гийн тусламж маш чухал байсан. АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга Жорж Маршалл 1947 оны 6 дугаар сард Харвардын их сургуулийн төгсөлтийн ёслол дээр Европыг сэргээн босгоход зориулсан нүсэр хөтөлбөрөө зарласан билээ. 1948-1952 оны хооронд Өрнөд Европын 17 оронд хэрэгжсэн 13 тэрбум ам. долларын өртөг бүхий (2016 оны үнэлгээгээр \$300 тэрбум) Маршаллын төлөвлөгөөг хэрэгжүүлэх эрхзүй, зохион байгуулалтын механизмийг 1948 онд Европын эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага нэртэйгээр үүсгэн байгуулжээ. Төлөвлөгөө хэрэгжиж, Өрнөд Европын орнуудын эдийн засаг сэргэн бэхжих явцад тэрхүү байгууллагыг өөрчлөн 1960 онд Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага буюу OECD болгон үйл ажиллагааны зорилго, агуулга, хүрээг нь өргөтгөсөн юм. Европыг сэргээн шинэчлэх энэхүү нүсэр төлөвлөгөөний зорилго, мөн чанар нь хүний эрх, эрх чөлөө, ардчилалын үнэт зүйлс, зах зээлийн эдийн засаг бүхий өөрийн найдвартай холбоотныг Өрнөд Европт буй болгох нь ирээдүйн АНУ-ын үндэсний аюулгүй байдал, эрхэм дээд эрх ашигт бүрнээ нийцэх учиртай байсанд оршино. Энэ нь АНУ-ын эдийн засгийн дипломат бодлогын гайхамшигт ялалт байсан гэж үзэж болно. Дурдсан төлөвлөгөөнд ЗХУ, түүний холбоотнуудыг хамруулах зорилготой 1948 оны Парисын бага хурал зохион байгуулагдсан ч ЗХУ, түүний шинэ холбоотнууд үүнийг Европыг капитализмжуулах хөтөлбөр хэмээн үзэж, түүнд оролцохоос татгалзаад зогсохгүй улмаар 1949 оны 1 дүгээр сард түүний эсрэг ЭЗХТЗ-ийг байгуулсан түүхтэй.

Тусламжийн энэхүү мега хөтөлбөр *Bretton Woods*-ын институтүүдээр дамжин хэрэгжсэн юм. 1952 он гэхэд Өрнөд Европын

эдийн засаг дэлхийн II дайны өмнөх түвшинд хүрч, 17 орны үндэсний мөнгөн дэвсгэрт ам.доллартай чөлөөтэй хөрвөх ханшинд шилжиж, дурдсан орнуудын төлбөрийн тэнцэл огцом сайжирсан байна. Японы хөгжилд ч чухал нөлөө үзүүлэв.

ОУВС 1952 оноос эхлэн гишүүн орнуудын төлбөрийн тэнцлийн хэвийн бус байдлыг арилгах зорилгоор *Stand-by* буюу “Богино хугацааны хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж эхэлжээ.

Азийн бар орнуудын хөгжилд ч чухал үүрэг гүйцэтгэсэн байна. Мэдээж Азийн шинээр аж үйлдвэржсэн буюу «Азийн бар» хэмээн нэрлэгдэх болсон орнуудын эдийн засгийн хөгжилд ОУВС маш чухал үүрэг гүйцэтгэсэн байна. 1960-аад оноос хойшх гурван 10 жилд буй болгосон энэ загвар нь *эдийн засгийн ардчлалыг хөгжүүлэх үндсэн дээр улс төрийн ардчлалыг хөгжүүлж* ирсэн явдалд түүний мөн чанар оршиж байв. Азийн шинээр аж үйлдвэржсэн Өмнөд Солонгос, Сингапур, Тайвань, Хон Конг зэрэг орнууд зах зээлийн эдийн засгийн тогтолцоог төрийн хүчтэй зохицуулалттай хослуулж, экспортын чиг баримжаатай үйлдвэрлэлийг хөгжүүлж ирсэн. Үнэхээр ч сайхь орнууд олон жил колончлолд байж, дэлхийн II дайны дараа дундад зууны эдийн засгийн харилцаа гүн суурьтай байсан нь Өрнөдийн орнуудын ардчилалыг тэр чигээр нь хуулбарлан авах боломж, нөхцөлийг бүрдүүлээгүй юм. 1950-иад оны сүүлээр Өмнөд Солонгос, Тайвань, Сингапур сонгодог либерализмын загварыг туршсан боловч тэр нь хөгжлийг түргэтгэх гол хүчин зүйл биш гэдэг нь удалгүй тодорхой болсон байна.

Хэдийгээр цэргийн болон авторитар дэглэм эдийн засагт хүчтэй оролцож байсан боловч зах зээлийн бодит хуулиудыг үр ашигтай хэрэглэж, нээлттэй бодлого явуулж чадвал эдийн засгийн зохих өндөрлөгт хүрч болохыг энэ туршлага харуулсан юм. Хятад, Вьетнам ч коммунист намын удирдлагын дор зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжиж энэ нь ч үр дүнгээ өгсөн билээ. Чилийн хөгжлийн туршлага ч аанай л нэгэн адил болой. Нээлттэй эдийн засаг, экспортын чиглэлтэй бүтэц, гадаадын шууд хөрөнгө оруулалт, олон улсын санхүүгийн байгууллагуудын зээл, тусламж чухал хүчин зүйл болсон гэдэг нь өнөөдөр ойлгомжтой. Мэдээж дурьдсан орнууд коммунист Хятад, Хойд Солонгостой бүх чиглэлд уралдаж байсан юм.

Азийн «шинээр аж үйлдвэржсэн» орнууд нийтлэг шинж бүхий хөгжлийн тодорхой үе шатуудыг дамжиж иржээ. Энэ нь нэгд: 1960-аад онд импортыг орлох үйлдвэрлэлийг бүх талаар хөхиулэн дэмжих, хоёрт, 1970-аад онд үйлдвэрлэлийн бүтцийг өөрчлөн хүнд үйлдвэр, экспортын чиг баримтласан үйлдвэрлэлийг түлхүү хөгжүүлэх, гуравт, 1980-аад оноос оюуны багтаамжтай өндөр технологи, цахим бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлэхэд чиглэгдэж иржээ. Дөрөвт, 1990-ээд оноос мэдээллийн технологийн салбарт дэлхийд тэргүүлэх байр суурь эзлэх явдал болов. Эдүгээ дурьдсан чиглэлд эдийн засгийн дипломат ажиллагаа нь үндсэндээ чиглэгдэж байна гэж хэлж болно.

Зүүн Ази, Номхон далайн хэсэг орон үйлдвэрлэлийн бүтцийг шинжлэх ухаан, технологийн үндсэн дээр шинэчилж, экспортын чиглэлтэй бодлого явуулснаар үндсэндээ хөгжлийн Японы загвараар эдийн засгийн өсөлтийг эрс хурдасгаж байгааг бүр 1975 онд Өрнөдийн стратегийн судалгааны нэртэй төвүүдийн дүн шинжилгээг үндэслэн Америкийн TIME сэтгүүл анхааруулан бичиж байжээ.

1997 оны 4 дүгээр сард ОУВС-гаас гаргасан “Дэлхий эдийн засгийн байдал төлөв” илтгэлд улс орнуудын хөгжлийн ангилалыг шинэчилж «*advanced economies*»-тай орнуудын тоонд Азийн шинээр аж үйлдвэржсэн 4 орон Сингапур, Өмнөд Солонгос, Тайвань, Хонг Конг болон Израилийг оруулсан байдаг.

Дэлхийн эдийн засагт 1997 оны 7 дугаар сард тохиолдсон үйл явдлын нэг нь Зүүн өмнөд Азийн орнуудын санхүү, эдийн засгийн хямрал байв. Монголчууд *морин жилийг* ихэд билэгшээхийн дээр өөрсдийгөө *бөрт чоноос* гаралтай гэж үздэг. Харин Солонгосчууд өөрсдийгөө *бараас* гаралтай гэж үздэг. 1998 оны 2 дугаар сарын 25-нд Үндэсний Ассамблейн ордны өмнө сөрөг хүчнээс анх удаа Ерөнхийлөгчид сонгогдсон Ким Дэ-жүнийн тангараг өргөх ёслолд зориулсан багт наадмын үеэр хүч тамир нь сульдсан асар том бар хэвтрээсээ өндийж архиран босч байгаа үзүүлбэр онцгой сэтгэгдэл төрүүлж билээ. Сүүлийн 30 гаруй жилийн түүхэнд Зүүн Азийн эдийн засгийн хөгжлийн гайхамшигийг буй болгож «Азийн бар» болсон энэ орон 1997 оны сүүлчээс эдийн засгийн гүн хямралд орсон ч 1998 оны Бар жилд дахин шинээр мэндэлж байгааг илтгэсэн хэрэг байв. Үнэхээр ч Солонгосчуудын хувьд жил нь орсон байв.

Энэхүү хямрал 1997 оны 7 дугаар сард Тайландад эхэлж улмаар Зүүн өмнөд Азийн хэд хэдэн оронд шууд нөлөөлсөн. 1997 оны 9 дүгээр сараас Малайзийн ринггит, Индонезийн рупий, Филиппины песо, Өмнөд Солонгосын воны ханш огцом унахад нөлөөлж, хямрал бүс нутгийн шинж чанартай болохыг харуулав. Гол шалтгаан нь эдийн засгийн хэт өсөлт буюу халалт, макроэдийн засгийн болон валютын арилжааны бодлогын алдаа, санхүүгийн секторын зохион байгуулалт, бүтэц сул, эдийн засагт төрийн оролцоо их байсан, мөн дэлхийн зах зээлийн нөлөө, дотоодын их хэмжээний авилга, хээл хахууль зэргийг дурьдахад хангалттай. Энэ үед дурьдсан орнууд ОУВС-тай эрсдлийн багц буюу *bailouts packages* гэсэн нэн хүнд болзолтой 1 жилийн хөтөлбөрийг хэрэгжүүлсэн. Энэ хүрээнд БНСУ 57, Тайланд 17, Индонез 20, Филиппин 15, Малайз 14 тэрбум ам. долларын зээлийг авч ашигласнаар эдийн засгаа богино хугацаанд өндийлгэж чадсан юм.

1960-70-аад онд Өмнөд Солонгосын удирдагч Пак Жөн-хигийн Засгийн газар эхний үед гадаадын шууд хөрөнгө оруулалтаас тодорхой хэмжээнд зайлсхийж, харин Бреттон Вүүдсийн интситүцтэй идэвхтэй хамтран ажиллаж, хөнгөлөлттэй болон ердийн зээл, буцалтгүй тусламж авах чиглэлийг баримталж байсан нь эдийн засгийн дипломатын зөв стратеги байсан гэж судлаачид үздэг. Энэ нь хойд хөрштэйгээ дайны байдалтай байсан хийгээд мөн ч үндэсний онцлог байдлыг харгалзсан хэрэг байлаа. 1970 оны эхнээс үе шаттайгаар гадаадын хөрөнгө оруулалтанд тааламжтай нөхцөлийг бүрдүүлж иржээ.

Дипломат ажиллагаанд гарч буй өөрчлөлт

Дэлхийн эдийн засаг даяаршиж, улс орнуудын харилцан хамаарал улам бүр гүнзгийрч, хөгжлийн асуудал тэргүүн зэрэгт тавигдах болсон орчин үеийн шатанд дипломат ажиллагаанд худалдаа, эдийн засаг, хөрөнгө оруулалт, санхүү, зээл, хөгжлийн тусламж, мэдээллийн технологи, хүрээлэн буй орчин, экологийн асуудал шинэ үүрэг гүйцэтгэх болсон явдал юм. XXI зууны олон улсын харилцааны шинж, төлөв нь асар хурдацтай хувьсал, өөрчлөлт, шинээр шийдвэрлэх дэлхий нийтийн болон үндэсний аюулгүй байдлын олон тулгамдсан асуудал болон мэдээлэл-технологийн үсрэнгүй хөгжилтэй уялдан цоо шинэ орон зай, орчин буй болж, олон улсын харилцааны оролцогчид нэмэгдэж, улс орны дотоод, гадаад бодлогын зааг ялгаа багасч, дэлхийн

эдийн засаг, зах зээлийн нөлөө, харилцан хамаарал ихэсч, улс орнууд урьд өмнө байгаагүйгээр харилцан хамаарал улам бүр гүнзгийрч буй өнөө үед олон улсын харилцааны сонгодог буюу уламжлалт дипломат ажиллагаа дангаар эдгээр асуудлыг шийдвэрлэх боломжгүй болов. Энэхүү геополитик, гео-эдийн засгийн шинэ орчинд эдийн засгийн дипломат ажиллагааны үүрэг, ач холбогдол хэлбэрэлтгүй өсөн нэмэгдэж, шийдвэр гаргах түвшинд мэдлэг, мэдээлэл, судалгаа, дүн шинжилгээнд суурилсан стратеги, уян хатан smart бодлого явуулах зайлшгүй шаардлага урган гарч ирэв.

Эдүгээ дипломат ажиллагаанд мэдлэг болон технологит суурилсан эдийн засгийн онол-аргазүй, шинжлэх ухааны үндэслэлийг боловсруулах, олон талт судалгаанд суурилсан дүн шинжилгээ, эрсдлийн үнэлгээ хийх зайлшгүй шаардлагатай болж байна. Хүн төрөлхтөн шинжлэх ухаан-технологийн урьд үзэгдээгүй ахиц, дэвшлийг Шинэ мянганд гаргах материаллаг болон оюун санааны үлэмж чадавхтай юм. Мэдээлэл, харилцаа холбооны технологи, өндөр технологийн суурь бүтэц, дэд байгууламж, нэг хүнд оногдох нийтийг хамарсан өндөр хурдны интернетийн сүлжээ, гол эдийн засгийн бүтцүүдийн хоорондох интегралчлал, инновацичлал улс орны хөгжлийн гол хэмжүүр болов.

Зарчмын цоо шинэ үүрэгтэй болсон мэдээлэл, харилцаа холбооны технологийн үсрэнгүй хөгжилтэй уялдан орон зай, цаг хугацаа, эдийн засгийн шинжлэх ухааны хуучин тодорхойлолтууд шинчлэгдэж, энэ нь эдийн засагт асар их хэмнэлт буй болгож, цаг хугацааны алдагдалыг үлэмж бууруулах болов. Нэг талаас дэлхий дахины худалдаа-эдийн засаг, зах зээлийн харилцаанд мөнгө, санхүү, хөрөнгө, ажиллах хүчний асар өргөн шилжилт хөдөлгөөн, бүтээгдэхүүн, үйлчилгээ, мэдлэг, мэдээллийн хил хязгааргүй урсгал явагдаж, улс орнуудын харилцан хамаарал урьд өмнө байгаагүйгээр гүнзгийрч, түүнд суурилсан даяаршсан макро шинэ ертөнц буй болж, нөгөө талд кибер хэмээх цоо шинэ орон зай, орчин буй болж, мэдээлэл, харилцаа холбооны технологийн хөгжлөөс үүдэн мэдээллийн ертөнцөд томоохон өөрчлөлтүүд гарч, мэдээллийн аюулгүй байдал хэмээх шинэ ойлголт буй болов.

XX зууны сүүлчийн улиралд хүн төрөлхтний нэг том нээлт нь амьдрах геополитикийн орон зайгаа цоо шинээр “тэлсэн” явдал юм. Энэ шинэ орон зайг цахим орон зай буюу cyber space гэх бөгөөд хүний оюуны бүтээл болсон энэ орон зай хүн төрөлхтний амьдралд язгуур өөрчлөлт гаргаж, цаашид ч олон өөрчлөлт, шинэ зүйлсийг буй болгох нь тодорхой байна. Бодит биет бүхий ертөнц цахим ертөнцөд виртуаль хэлбэртэй болж байгаа нь түүний хамгийн түгээмэл шинж юм. Кибер технологийн хурдацтай хөгжлийн үг дагавараар дэлхий нийтийн аюулгүй байдал улам их эрсдэлтэй болж, санамсаргүй байдлаар өчүүхэн зүйлээс ч асар их хор хөнөөл учирч болзошгүй байдал үүсээд буй.

Үндэсний эдийн засаг дэлхийн зах зээлийн хуулиар зохицуулагдаж, үндэсний баялаг, түүхий эдийн нөөцөө захиран зарцуулах нь нэг улсын эрх мэдэл, хил хязгаараас шалтгаалахгүй болж, гадаад, дотоод бодлогын зааг ялгаа багасч байна. Цахим ертөнц ганцхан мэдээлэл солилцох хэрэгсэл байхаа хэдийнээ больж, хил хязгааргүй эдийн засгийн нэгдсэн нэг орон зай болон хувирав. Өөр өөр соёл иргэншил, эдийн засаг, эрхзүйн тогтолцоотой 200 гаруй улс гүрэн интернетэд холбогдож, цахим сүлжээ нь бизнес, олон улсын худалдаа, хөрөнгө оруулалт, татвар, мэдээлэл, боловсрол, теле холбоо, ажил эрхлэлт, эрүүл мэнд, батлан хамгаалах гээд нийгмийн бүхий л харилцааг өөртөө нэгтгэж байна.

АНУ-ын гадаад бодлогын хөтөлбөрийн цөм нь *economic statecraft* буюу төрийн үйл ажиллагааг эдийн засгийн арга барилаар явуулах ур чадварыг эзэмшихэд оршиж байна.

АНУ-ын Ази, Европ дамнасан дипломат бодлогод эдийн засгийн үүрэг улам нэмэгдэж байгаа бөгөөд гадаад бодлогоо тодорхойлохдоо: *economics of power* буюу хүчний эдийн засаг, *power of economics* буюу эдийн засгийн хүч гэсэн 2 зарчмыг баримталж байна.

Гэхдээ НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн шийдвэрээс гадуур эдийн засгийн хориг арга хэмжээ өргөжиж, Европын интеграци, бүс нутгийн болон их гүрнүүдийн хоорондын олон талт болон хоёр талт чөлөөт худалдааны хэлэлцээр томоохон сорилтуудтай тулгарч, *Brexit* шинэ нөхцөл байдлыг буй болгов. АНУ-ын шинэ ерөнхийлөгчийн “Америк нэгдүгээрт” гэсэн эдийн засгийн протекционист, дангаарчлах бодлого

АНУ-ыг Номхон далай дамнасан түншлэлийн хэлэлцээр, НҮБ-ын уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх Парисын хэлэлцээрээс гаргахад хүргэж, хөгжлийн тусламжийг танаж эхлэв. АНУ-ын *top sales diplomacy* НАФТА, Транс-Атлантикийн хэлэлцээг шинээр эхлүүлэх төлөвтэй байна.

Нөгөө талд ОХУ, БНХАУ-аар тэргүүлсэн олон улсын харилцааны олон туйлт дэлхийн шинэ дэг тогтолцоо бүрэлдэж буй үед эдийн засгийн дипломат ажиллагаанд ОХУ-ын оройлолтой Евразийн эдийн засгийн холбооны нэгдсэн зах зээлийн үйл явц, БНХАУ-ын «нэг бүслүүр, нэг зам» Евразийг дамнасан дэд бүтэц, ложистикийн мега төсөл чухал байр суурь эзлэх болов.

Эдийн засгийн бодлогод supply chain connectivity буюу шүтэлцээний барилдлагыг хангах, хүртээмжтэй буюу inclusive, тогтвортой буюу sustainable, тэнцвэртэй буюу balanced, шинэ үзэл баримтлал, технологид суурилах буюу innovative байх нь амжилтын тулгуур үндэс болж байна.

ОУВС-гийн хөтөлбөрүүд Монголд амжилттай хэрэгжсэн нь

ОУВС Монголд хэзээ ч сөрөг үр дагавар тарьж байгаагүйгээр барахгүй хөтөлбөрүүд нь амжилттай хэрэгжсэн гэдгийг тэмдэглэх ёстой. Монгол Улс ОУВС, Дэлхийн банкны бүлгийн хэлэлцээрт 1991 оны 2 дугаар сарын 14-нд нэгдэн оржээ. Үүнээс хойш даруй 27 жил өнгөрсөн байна.

Энэ хугацаанд нэгд, *stand-by* хөтөлбөрийн хэлэлцээрийг Монгол Улс анх зах зээлийн эдийн засагт шилжсэн анхны хүнд жилд төлбөрийн тэнцлийг дэмжих зорилгоор 1991 оны 10 дугаар сард байгуулсан. Уг хөтөлбөрийн дагуу 13.75 сая зээлжих тусгай эрх (ЗТЭ буюу special drawing rights SDRs⁴) буюу 20 сая ам.доллар, 6.5 хувийн хүүтэй зээлийг 1991-1992 онуудад авч ашиглан буцаах төлбөрийг 1997 онд бүрэн төлж барагдуулсан байдаг. *Хоёрт, Бүтцийн өөрчлөлтийг эрчимжүүлэх хөтөлбөр-1* буюу ESAF (Enhanced Structural Adjustment Facility). Мөн төлбөрийн тэнцлийг дэмжих зорилгоор 1993 оны 6 дугаар сарын 25-нд байгуулсан байна. Хөтөлбөрийн дагуу 40.8 сая ЗТЭ буюу 59.0 сая

4 ОУВС-гийн Арвын бүлэг 1 ЗТЭ-ийг 0.888761 граммын алтан агуулгатайгаар 1970 оны 1 дүгээр сараас Өрнө дахины олон улсын валют-санхүү, зээлийн системд нэвтрүүлсэн данснаас дансанд бичилт хийх замаар явагддаг нэгж юм.

ам.доллар, 0.5 хувийн хүүтэй зээл амласнаас 1993-1996 онуудад нийтдээ 29.68 сая ЗТЭ буюу 44.8 сая ам.доллар авч ашигласан байна. Зээлийг 2006 онд эргэн төлж барагдуулжээ. *Гуравт, Бүтцийн өөрчлөлтийг эрчимжүүлэх хөтөлбөр-2 (ESAF-2)*-ыг мөнхүү макро эдийн засгийг тогтворжуулах, бүтцийн өөрчлөлтийг эрчимжүүлэх зорилгоор 1997 оны 7 дугаар сараас хэрэгжүүлж эхэлжээ. Хөтөлбөрийн дагуу 33.4 сая ЗТЭ буюу 48.0 сая ам.доллартэй тэнцэх хэмжээний, 0.5 хувийн хүүтэй зээл амласнаас 1997-2000 онуудад нийтдээ 17.44 сая ЗТЭ буюу 23.7 ам.доллар авч ашиглажээ. Зээлийн үндсэн өрийн төлбөрийг 2003 оны 2 дугаар сараас 2010 оны 1 дүгээр сарын хооронд барагдуулсан байна. *Дөрөвт, ОУВС* 1999 оны 9 дүгээр сард шинээр буй болгосон Ядуурлыг бууруулах, өсөлтийг хангах хөтөлбөр (PRGF-Poverty Reduction and Growth Facility)-т 2001 оны 9 дүгээр сард 3 жилийн хугацаанд Монгол Улсад хэрэгжүүлэхээр шинээр баталжээ. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд нийтдээ 28.49 сая ЗТЭ буюу 36.9 сая ам. доллартай тэнцэх зээлийг авч үр дүнтэй ашиглажээ.

1990 оны 7 дугаар сард АНУ-ын Хьюстон хотноо болсон Их Долоогийн бүлэг, ЕЭЗХН-ийн жил тутмын дээд уулзалтаас гаргасан улс төрийн Тунхаглалд Монголд өрнөсөн ардчилсан үйл явцыг тууштай дэмжих тухай заалт анх удаа тодорхой тусгагджээ. 1991 оны 7 дугаар сард Лондонд болсон Долоогийн бүлэг, ЕЭЗХН-ийн дээд уулзалтын баримт бичигт Монгол Улсад олон улсын тусламж үзүүлэх талаар заалт орсон юм. Уулзалтад Их Британий Ерөнхий сайд Жон Межорын урилгаар ЗХУ-ын Ерөнхийлөгч М.С. Горбачёв анх удаа оролцсоноор 7+1 хэмээх бүтэц бий болжээ. Энэ зөвлөгөөний шийдвэрийг үндэслэн Японы Засгийн газрын санаачилагаар ОУВС, Дэлхийн банктай хамтран Монголд хандивлагч орнуудын анхдугаар чуулга уулзалт 1991 оны 9 дүгээр сард Токиод зохиогдсон юм.

2003 онд Токиод болсон уулзалтаар шилжилтийн үе дууссаныг албан ёсоор зарлаж хандивлагчдын бүлэг татан буугдсан. Нийт 12 жилийн хугацаанд Монгол Улс хөгжлийн зээл 1.100 тэрбум ам. долл, буцалтгүй тусламж 1.300 тэрбум ам. долл авч ашигласан нь Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд ямар чухал үүрэг гүйцэтгэснийг нотлох шаардлагагүй.

Монгол Улсын Засгийн газар АНУ-аас үүдэлтэй дэлхийг хамарсан 2008-09 оны санхүү-эдийн засгийн хямралыг даван туулах, төсвийн тогтвортой байдлыг хангах, төсвийн алдагдлыг бууруулах, эдийн засгийг тогтворжуулах зорилгоор ОУВС-тай “Stand-by” хөтөлбөрийг 2009 оны 3 дугаар сард байгуулж, улмаар тус сангийн Захирлуудын зөвлөлөөр 2009 оны 4 дугаар сарын эхээр батлагдсан байна. Уг хөтөлбөр нь 18 сарын хугацаанд хэрэгжсэн байх бөгөөд эдийн засгийг тогтворжуулах төсөв, мөнгөний бодлогыг тодорхойлж зорилтот шалгуур үзүүлэлтүүдийг гаргасны дээр банкны систем, нийгмийн хамгааллын салбарын асуудлуудыг хамарсан бүтцийн шалгууруудыг мөн багтаасан байна. Хөтөлбөрийн хүрээнд Монгол Улс ОУВС-гаас жилийн 5 хувийн хүүтэй ойролцоогоор 153.3 сая ЗТЭ буюу 229.2 сая ам. долларын тусламжийн зээл авчээ. Тухайн үед Засгийн газар төсөвтөө гурван ч удаа тодотгол хийж, орлого, зарлагаа өмнөх оныхоос 18 хувиар бууруулж, үр дүнд нь эдийн засгийн өсөлт 2009 онд 1.6 хувьтай гарч байсан юм. Зээлийг 2011 онд амжилттай төлж барагдуулсан байна.

ОУВС-гийн хөтөлбөрүүд зарим орнуудад амжилт олоогүй нь социалист үзэлт Латин Америк, зах зээлийн эдийн засгийн харилцаа нэн сул, ардчилсан засаглалгүй улс төрийн дэглэмтэй Африкийн орнуудад амжилт олоогүй. Хүйтэн дайны үед Румын, Польш улсад хэрэгжүүлсэн ОУВС-гийн хөтөлбөрүүд амжилт олоогүйгээр барахгүй дурьдсан улсууд асар их өрөнд орсон байдаг. Учир шалтгаан нь маш тодорхой бөгөөд социалист өмч ноёрхсон, төлөвлөгөөт эдийн засгийн систем, ОУВС-гийн систем хоёр хоорондоо хэзээ ч авцалдахгүй байсан явдалд оршино. Гэтэл булангийн орнууд болох АНЭУ, Катар, Кувейт, Бахрейн өнөөдөр эдийн засгийн гайхамшигийг үзүүлж байгаа билээ.

ЕХ-нд гишүүнээр элссэн Төв, Зүүн Европын пост-коммунист орнуудын эдийн засагт Bretton Woods Institutions маш чухал үүрэг гүйцэтгэсэн юм. Мэдээж ОУВС-гийн хөтөлбөрүүд шулуун дардан замаар хэрэгжиж байгаагүй. Эдийн засаг өөрөө нарийн, баялаг бөгөөд адармаатай.

Шинэ Засгийн газрын эдийн засгийн дипломат бодлогын шинэ парадигм

Өнгөрсөн жилүүдэд Чингис бонд, самурай бонд, хөгжлийн банкны зээл эерэг нөлөө үзүүлж чадсангүй. Энэ бол бонд нэртэй богино хугацаат, өндөр хүүтэй арилжааны зээл байсан нь улс орны амьдралыг бүхэлд нь нэн хүнд байдалд оруулсан байна. Арилжааны зээл авах цаг нь болоогүй байсныг хөөсөн өсөлт харуулав. Бид 2011 оны «гайхамшиг»-т дэндүү тайвширч жин нэмж барилдана хэмээн сайрхаж, бараг бүх зүйл дээр мөнгө амалж байлаа. Төсвийн бодлого, төв банкны бодлого шинжлэх ухаанд суурилсангүй. Ийм үе шатыг дамжих ёстой байсан байж магадгүй юм.

Bretton Woods Institutions-тэй үр ашигтай уян хатан хамтран ажиллаж, Мянганы хөгжлийн зорилтуудыг амжилттай шийдвэрлэх нь эдийн засгийн дипломатын чухал чиглэл мөн билээ. Шинэ Засгийн газрын эдийн засгийн дипломатын шинэ парадигм нь улс орныг хямрлаас гаргах гарцыг ОУВС-тай тохиролцох явдал гэж үзсэн нь зөв чиглэл юм.

Одоогийн ОУВС-тай хийсэн 440 сая ам.долларын “Өргөтгөсөн сангийн хөнгөлөлт” (Extended Fund Facility) хөтөлбөр нь Монгол Улсын хөгжилд эерэг зүйл авчиргах төлөв ажиглагдаж байна. ОУВС-тай тохиролцсон явдал нь бусад гүрнүүд, олон улсын санхүүгийн байгууллагын зээлийн замыг нээж өглөө. Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн хүрээнд ОУВС, олон улсын санхүүгийн байгууллага, хандивлагч орнуудаас нийт 5.5 тэрбум ам.долларын хөнгөлөлттэй зээл авахаар тохирсон бөгөөд үүний 2 тэрбум ам. доллар нь Хятадын Ардын банктай байгуулах юанийн своп хэлцэл байх ажээ. Тэгвэл Азийн хөгжлийн банк 900, Дэлхийн банк 600 сая ам.доллар зээлдүүлэх юм. ОУВС болон Азийн хөгжлийн банкны зээлийн 600, ОУВС зээлийн 440 сая ам.долларыг төсвийн алдагдлыг тэнцвэржүүлэхэд зарцуулах юм байна. Эдгээр зээл нь 15 жилийн хугацаатай, гурван хувийн хүүтэй байх ажээ. Үлдсэн 1.3 тэрбум ам.долларыг Япон, БНСУ зэрэг орноос хөтөлбөр хэрэгжүүлэх гурван жилийн хугацаанд авахаар болов.

ОУВС биднийг гуйгаагүй, бид л хандсан гэдгийг тэмдэглэх ёстой. Зарим нэг процедурын алдаа гарч байгаа ч ирээдүйд гарах үр

ашигтай нь харьцуулахад энэ бол харьцангуй жижиг зүйл юм. Эрдэнэс тавантолгой, Оюутолгойн төслүүд идэвхжих хандлагатай байна.

Эдийн засагт сэргэлт гарч байгааг тэмдэглэх ёстой. ДНБ 2017 оны эхний улиралд 30.6 их наяд төгрөг болсон байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 122.7 тэрбум төгрөгөөр буюу 4.2 хувиар өссөн үзүүлэлт ажээ. Аж үйлдвэрийн салбарын нэмэгдэл өртөг 28.3 тэрбум төгрөгөөр буурсан ч үйлчилгээний салбарынх 89.9, бүтээгдэхүүний цэвэр татвар 54.8 тэрбумаар өссөн нь үүнд голлон нөлөөлжээ. ДНБ-ийг өнөөгийн үнэ цэнээр тооцвол 2017 оны эхний улиралд 57.2 их наяд төгрөгт хүрсэн байна. Үүнийг өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулбал, 991.4 тэрбум төгрөгөөр буюу 20.9 хувиар өссөн үзүүлэлт юм.

Түүхийн эдийн дэлхий зах зээлийн үнийн одоогийн өсөлт нь дээрх бодлогыг хэрэгжүүлэхэд тус дөхөм үзүүлнэ.

ОУВС-гийн хөтөлбөр гурван жилийн хугацаатай хэрэгжих бөгөөд улирал тутам үнэлгээ хийх юм. Хөтөлбөрийн эхний үе шатны үнэлгээ хийх ОУВС-гийн ажлын хэсэг 2017 оны долоо, наймдугаар сарын заагт Монгол Улсад ажиллаж, хөтөлбөрийн хэрэгжилт, Засгийн газар, Монгол банкнаас авч хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээний хэрэгжилт, тоон үзүүлэлтүүдэд урьдчилсан байдлаар үнэлгээ хийж, Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны дарга нартай уулзжээ. Чингээд ОУВС-гийн ажлын хэсгийн ахлагч Коши Матай дараах мэдэгдлийг гаргажээ. Мэдэгдэлд: Эдийн засаг сэргэж байна. Нүүрс олборлолт, экспорт эрчимтэй нэмэгдэж, хувийн хөрөнгө оруулалт их хэмжээгээр өсч, ОУВС тэргүүтэй хөгжлийн түншүүдийн 5.5 тэрбум ам.долларын санхүүжилт батлагдсаны дараагаар эдийн засагт итгэх итгэл сэргэсний ачаар ДНБ 2017 онд хоёр хувийн өсөлттэй гарахаар байна. Хөтөлбөр сайн хэрэгжиж, бүх тоон зорилтууд хангагдсан. Төсвийн орлого давж, зарлагын санхүүжилтийг хатуу хяналтанд байлгасны үр дүнд төсвийн үр дүнгийн үзүүлэлтүүд тооцоолсноос хавьгүй сайн биелж гарлаа. Давж биелсэн орлогын дүнгийн тал орчим хувиар хуримтлал үүсгэснээр, зээллэгийн хэмжээг бууруулан өрийн өсөлтийг хязгаарлах болно. Үлдэх хэсгийг Засгийн газрын мөрийн хөтөлбөрт тусгагдсан үр өгөөжтэй арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна. Гадаад валютын цэвэр нөөцийн хэмжээ өссөн нь экспортын орлого нэмэгдэж, Засгийн

газрын үнэт цаасны зах зээлд гаднаас хөрөнгө оруулалт хийгдэж буйтай холбоотой. Эрх баригчид дунд хугацаанд эдийн засгийн өсөлтийг хадгалахад чиглэгдсэн бүтцийн өөрчлөлтийн томоохон зорилтуудаа хэрэгжүүлж эхлээд байна. Банкны системийг бэхжүүлэх ажил хийгдэж байна. Активын чанарын үнэлгээг удахгүй эхлүүлнэ.

Төсвийн тал дээр татварын удирдлага, татварын бодлого, төсвийн хяналтыг бэхжүүлэх ажил ахицтай явагдаж байна. Мөн төсвийн зөвлөлийг байгуулна. Нийгмийн хамгааллын тогтолцоог боловсронгуй болгож, зардлыг нэн эмзэг бүлэгт чиглүүлэх үүднээс Засгийн газар Хүүхдийн мөнгө хөтөлбөрийг эргэн харж байна. Уг хөтөлбөрийг 2018 оноос эхлэн хөрөнгө чинээ багатай өрхүүдэд чиглүүлж, хэмнэгдсэн хөрөнгийг ядууст зориулсан хүнс тэжээлийн нэмэгдэл хөтөлбөрийн санхүүжилтийг нэмэгдүүлэхээр амлалт өгсөн. Эрх баригчид болон ажлын хэсэг Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн эхний шатны үнэлгээн дээр ажлын хэсгийн түвшинд тохиролцлоо.

ОУВС-гийн Захирлуудын зөвлөл 2017 оны 9 дүгээр сарын сүүлээр хуралдаж, эхний шатны энэхүү үнэлгээг эцэслэхээр төлөвлөж, ингэснээр 27.9560 сая ЗТЭ буюу 37.82 сая ам. долларын дараагийн санхүүжилт олгогдох ажээ.

Харин Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга тэмдэглэхдээ: нүүрсний үнэ дэлхийн зах зээл дээр өсөхөд Монгол Улсын төсвийн орлого нэмэгдэж байгааг амжилт гэж харахгүй байгаагаа ч дурдаж, учир нь, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, экспортлохгүйгээр улс орон хөгжиж, эдийн засаг сайжирах боломжгүй, түүхий эдийн үнийн өсөлт бол зөвхөн түр зуурын л үзэгдэл хэмээн онцолсон байна. Энэ тухайд ОУВС байр сууриа илэрхийлэх ёстой гэдгийг сануулав. Мөн тэрбээр “Монгол Улс хүүхдийн мөнгө өгч байгааг та бүхэн халамж гэж харж байгаа бол энэ тийм биш. Энэ бол хоёр том хөршийн дунд оршдог цөөн хүн амтай улсын хувьд хүн амаа өсгөх бодлого” хэмээн хэллээ. Монгол Улсын арилжааны банкууд зээлийн барьцаанд мал авч байгааг ОУВС хүлээн зөвшөөрөхөөс таггалзаж байгаа талаар Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга дурдаад “Мал гэдэг бол монголчуудын хувьд үндсэн хөрөнгө” хэмээн сануулсан байна. Ерөнхийлөгчийн дээрх байр суурь бол зөв зүйтэй, ул үндэстэй тул Засгийн газар, Монгол банк үүнийг үйл ажиллагаандаа мөн анхаарах ёстой болов уу.

Шинэ Засгийн газрын ЕАЭЗХ, БНСУ, БНХАУ-тай чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах талаар анхаарч байгаа нь жижиг, эмзэг, экспортын чадавх сул эдийн засагтай Монгол орны хувьд үүнийг сайтар нягтлан гадаад эдийн засгийн хамтын ажиллагааны бодлого явуулах шаардлагатай.

ОУВС-гийн хөтөлбөрийг чухамхүү Маршаллын төлөвлөгөө лугаа зөв ашиглаж чадвал том үр дүнд хүрч монголын ард түмэн хожих ёстой.